

Тогтоол, захирамж, тушаал ИМЭТ

Бүртгэсэн		Гарчиг
Огноо	Дугаар	Машинны нийтлэл төлөгчид шарьдлуудын шинэчлэл батлах байх?
8/20	8/670	

сар, өдөр

~~Мөнхтөгс Т. Ганзориг~~  
~~Төрийн захирал~~  
~~Х~~



**ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2015 оны 10 сарын 20 өдөр

Дугаар A/640

Улаанбаатар хот

**Шалгалтын нислэгт тавигдах  
шаардлагуудыг шинэчлэн батлах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалт, ИНД-171 “Агаарын навигацийн үйлчилгээний техникийн байгууллага үйл ажиллагаа ба гэрчилгээжүүлэлт” дүрмийн 171.59 (д) дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Шалгалтын нислэгт тавигдах шаардлага”-ыг хавсралтаар шинэчлэн баталж, 2015 оны 10 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Шалгалтын нислэгт тавигдах шаардлагуудын дагуу үйл ажиллагаандаа зохицуулалт хийхийг Шалгалтын нислэг, зураглалын алба /Н.Батсайхан/-нд, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга бөгөөд Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын газрын дарга /Д.Батчулуун/-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2012 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/395 дугаар, Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын газрын даргын 2013 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/62 дугаар, 2015 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/03 дугаар тушаалуудыг тус тус хүчингүйд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

Г.НЯМДАВАА

## ШАЛГАЛТЫН НИСЛЭГТ ТАВИГДАХ ШААРДЛАГУУД

### А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

#### Нэг. Зорилго

(а) Энэхүү баримт бичгийг ИНД-171.59, ИНД-173.57-ийн заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор батлан гаргасан бөгөөд агаарын навигацийн үйлчилгээнүүдийн байгууламж, тоног төхөөрөмжүүд болон нислэгийн журмуудад хийх шалгалтын нислэгүүдэд тавигдах шаардлагуудыг тодорхойлсон болно.

(б) Монгол Улсын нутаг дэвсгэрт шалгалтын нислэг гүйцэтгэх байгууллага, түүний ажилтнууд, ашиглагдах тоног төхөөрөмжүүд тэдгээрийн аюулгүй ажиллагаанд тавигдах шаардлагуудыг тогтооход оршино.

(в) Шалгалтын нислэгийн үйлчилгээ эрхлэх байгууллага нь энэхүү шаардлагуудыг хэрхэн хангаж ажиллах талаар Үйл ажиллагааны заавартаа тодорхой заасан байна.

#### Хоёр. Хамрах хүрээ

(а) Энд заагдсан шалгалтын нислэгт тавигдах шаардлагууд нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээрх агаарын навигацийн үйлчилгээний тоног төхөөрөмж, байгууламжууд болон Монгол Улсын агаарын зайд үйлчлэх нислэгийн журмуудад хийгдэх бүхий л шалгалтын нислэгүүдэд хамаарна.

(б) Газрын байрлал тогтоох болон агаарын хөлгөөс тандах, турших гэх мэт нислэгүүдэд энэ шаардлагууд хамаарахгүй.

(в) Энэ шаардлагыг ICAO-ийн Doc 8071-д нийцүүлэн боловсруулсан болно.

### Б БҮЛЭГ. ШАЛГАЛТЫН НИСЛЭГИЙН БАЙГУУЛЛАГАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

#### Гурав. Хүний нөөцөд тавигдах шаардлага

(а) Шалгалтын нислэг үйлдэх байгууллага нь дараах албан тушаалтан, ажилтантай байна. Үүнд:

- 1/ Шалгалтын нислэгтэй холбоотой бүх үйл ажиллагаа энэхүү шаардлагад нийцэж, санхүүжиж байгааг бататгах, хяналт тавих, хариуцлага хүлээх удирдах албан тушаалтан;
- 2/ Байгууллагын үйл ажиллагаа энэхүү шаардлагыг хангаж байгааг бататгах, хянах үүрэг хүлээсэн, энэ зүйлийн (а)-ийн 1/-д заасан удирдах албан тушаалтанд шууд захирагдах албан тушаалтан;

3/ Байгууллага нь энэ зүйлийн (б)-д заагдсан журмын дагуу зохих сургалтад хамрагдсан ажилтантай байна.

(б) Шалгалтын нислэг үйлдэх байгууллага нь ICAO-ийн Doc 7192, Part E-2-т заасан стандартад нийцсэн дараах зүйлсийг багтаасан ажилтнуудын ур чадварыг үнэлэх, дадлагажуулах, хадгалах, эрх олгох журамтай байна. Үүнд:

- 1/ Ажилтнуудыг сонгон шалгаруулах, сургаж дадлагажуулах;
- 2/ Ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг хадгалах, дээшлүүлэх.

(в) Ажилтнуудын мэргэжил болон мэргэшлийн бэлтгэлийн талаар бүртгэл хөтлөх журамтай байна.

(г) Үйл ажиллагааны зааварт заагдсан шалгалтын нислэгийн ажилтнууд болон нислэгийн журмуудын шалгалтын нислэг, тэдгээртэй холбогдолтой үйл ажиллагааг хийж гүйцэтгэх ажилтнууд нь тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах мэргэжил, дадлага туршлагатай байна.

(д) Шалгалтын нислэгийн байгууллага нь зөвхөн дараах шаардлагыг хангасан тохиолдолд шалгалтын нислэгийг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- 1/ Тухайн шалгалтын нислэгээр шалгалт тохируулгыг хийж гүйцэтгэх бэлтгэгдсэн ажилтнуудтай байх;
- 2/ Тухайн систем, байгууламжийн шалгалт тохируулгыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмжтэй байх;
- 3/ ICAO-ийн Doc 8071 баримт бичгийн дагуу шалгалтын нислэгийн төрөл тус бүрээр боловсруулан гаргаж Шалгалтын нислэгийн байгууллагын Үйл ажиллагааны зааврын иж бүрдэл, эсхүл Хавсралт болгон баталгаажуулсан шалгалтын нислэгийн журмуудтай байх;
- 4/ Нислэгийн журмын баталгаажуулалтын хувьд бэлтгэгдсэн ажилтнуудтай байх.

### **Дөрөв. Техникийн ерөнхий шаардлага**

(а) Шалгалтын нислэгийн тоног төхөөрөмж нь шалгагдах байгууламжуудын шаардлагатай хэмжигдэхүүнийг хэмжих боломжтой байна.

(б) Байгууллага нь дараах материалыг бүрдүүлж, бүртгэл үүсгэн, хяналтандаа байлгана. Үүнд:

- 1/ Шалгалтын нислэгийн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгчээс гаргасан техникийн тодорхойлолтууд, техникийн өгөгдлүүд бүрдэл хэсэг тус бүрээр;
- 2/ Шалгалтын нислэгийн аливаа тоног төхөөрөмжийг бүхэлд нь эсхүл бүрдэл хэсгийн тохиргоог өөрсдөө гүйцэтгэдэг бол түүнд ашиглагддаг тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгчээс гаргасан техникийн тодорхойлолтууд, техникийн өгөгдлүүд бүрдэл хэсэг тус бүрээр;
- 3/ Энэ зүйлийн 2/-т тодорхойлогдсон тоног төхөөрөмжийг тохируулах заавар, аргачлалууд;

- 4/ Шалгалтын нислэгийн тоног төхөөрөмжүүдийн агаарын хөлөгт суурилуулагдах зураг, дизайн ба чанар баталгаажуулалтын инженерийн дүгнэлт;
- 5/ Агаарын хөлөгт суурилуулагдах антеннуудын төрөл, тодорхойлолтууд ба байрлалууд;
- 6/ Хэмжилтийн тоног төхөөрөмжүүдэд ашиглагддаг програм хангамжийн ашиглалтын зааврууд.

(в) Шалгалтын нислэгийн тоног төхөөрөмжүүд болон агаарын хөлгийн тоног төхөөрөмжүүд хоорондоо нөлөөлөхгүй байгаад чанар баталгаажуулалтын инженер нь тухайн агаарын тээвэрлэгчийн аюулгүй ажиллагаа, чанар баталгаажуулалтын ажилтантай хамтран баталгаажуулна.

(г) Шалгалтын нислэгийн хэмжилт, шалгалтын тохиргооны иж бүрдэл төхөөрөмж нь агаарын хөлгийн байрлалыг тодорхойлж, бичлэг хийх боломжтой байна;

(д) Шалгалтын нислэгийн хэмжилт, шалгалтын тоног төхөөрөмж нь шалгагдаж буй тоног төхөөрөмжийн хэмжигдэж буй өгөгдлийг бичиж, хадгалах төхөөрөмжтэй байна.

(е) Шалгалтын нислэгийн хэмжилт, шалгалтын тоног төхөөрөмж нь шалгагдаж буй навигацийн тоног төхөөрөмжийн дуудлагыг сонсох тоноглолтой байна.

(ё) Бүх хэмжилтийн тоног төхөөрөмжүүд нь үндэсний болон олон улсын холбогдох стандартыг хангаж байгаад хяналт тавих аргачлалтай байх ба өгөгдлүүдийн бүртгэлийг гаргасан байна.

#### **Тав. Агаарын хөлөг ба шалгалтын нислэгийн багт тавигдах шаардлага**

(а) Шалгалтын нислэгт ашиглагдах агаарын хөлөг нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 1/ Шалгалтын нислэг хийх агаарын хөлөг нь тухайн шалгалтын нислэгийг гүйцэтгэх чадвар бүхий нислэгийн чадамжтай байна;
- 2/ ИНЕГ-аас олгосон, эсхүл хүлээн зөвшөөрөгдөх агаарын хөлгийн гэрчилгээтэй байна;
- 3/ Шалгалтын нислэгийн тоног төхөөрөмжийг суурилуулах боломжтой байна;
- 4/ Шалгалтын нислэгийн хэмжилтийн тоног төхөөрөмж болон нэмэлт тоноглолуудыг суурилуулахад хангалттай зайтай байна;
- 5/ Шалгалтын нислэгийн хэмжилтийн тоног төхөөрөмж болон нэмэлт тоноглолуудыг хангах тогтвортой цахилгаан тэжээлийн эх үүсвэртэй байна;
- 6/ Агаарын хөлгийн радарын транспондерт үйлдвэрлэгчээс гаргасан техник үйлчилгээний хөтөлбөрийн дагуу баталгаажуулалт хийгдсэн байна;
- 7/ Шалгалтын нислэг гүйцэтгэх агаарын хөлөг нь автоматаар нислэг үйлдэх чадамжтай байна.

(б) Шалгалтын нислэгийн баг нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1/ Шалгалтын нислэгийн баг нь 2 нисэгч, шалгалтын нислэгийн төрлөөс хамаарч нэг эсхүл 2 инженер техникийн ажилтанаас бүрдэнэ;

2/ Нислэгийн журмыг нислэгээр баталгаажуулах болон тоног төхөөрөмжийг нислэгээр шалгах нисэгч нь хэрэглэлийн нислэгийн эрх эзэмшсэн, 1500-аас дээш нислэгийн цагтай дадлага туршлагатай байна;

3/ Хэрэглэлээр ойртолт үйлдэх нислэгийн журмыг нислэгээр баталгаажуулах нисэгч нь ICAO-ийн Doc 9906 /Quality Assurance Manual for Flight Procedure Design/, Volume VI /Flight Validation Pilot Training and Evaluation/ баримт бичгийн шаардлагын дагуу мэргэшсэн, дадлага туршлагатай байна;

4/ Шалгалтын нислэгийг гүйцэтгэх нисэгч нь ICAO-ийн Doc 8071 /Manual on testing of radio navigation aids/ Volume I /Testing of ground-based radio navigation systems/ баримт бичгийн шаардлагын дагуу мэргэшсэн, дадлага туршлагатай байна;

5/ Шалгалтын нислэгийн инженер нь ICAO-ийн Doc 7192, Part E-2-н дагуу сургалтад хамрагдсан, Doc 8071 /Manual on Testing of Radio Navigation Aids/ баримт бичигт заасны дагуу мэргэшсэн, дадлага туршлагатай байна,

### **Зургаа. Тоног төхөөрөмжийн антенд тавигдах шаардлага**

(а) Агаарын хөлөгт суурилуулагдсан шалгалтын нислэгийн тоног төхөөрөмжийн антеннууд нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 1/ Навигацийн тоног төхөөрөмжийн сигнал нислэгийн ямар ч үед хаагдахгүй байрлалд суурилуулагдсан байх;
- 2/ Шалгалтын нислэгийн хэмжилт хийхэд сигналийн ямар нэгэн хазайлт үүсгэхгүй байх ба агаарын хөлгийн бие даасан байрлал тодорхойлох системд ямар нэгэн нөлөөлөл үүсгэхээргүй байхаар тус тус байрлуулсан байх;
- 3/ Сэнсний модуляц зөвшөөрөгдөх доод төвшингөөс бага байх байрлалд суурилагдсан байх.

### **Долоо. Радио холбоо**

(а) Байгууллага нь шалгалтын нислэгийн үед агаар-газар хоёр талын радио холбоонд ашиглах давтамжийн зөвшөөрлийг холбогдох эрх бүхий байгууллагаас авсан байна.

(б) Шалгалтын нислэгийн үед нисгэгч-нислэгийн удирдагчийн радио холбооны үйл ажиллагаанд саад учруулахгүй байх үүднээс шалгалт тохируулгын үйл ажиллагаанд ашиглах бие даасан радиостанцтай байна.

### **Найм. Тоног төхөөрөмжийн ашиглалтын шаардлага**

(а) Байгууллага нь шалгалтын нислэгийн тоног төхөөрөмжийн хяналт, тохируулга болон ашиглалтын үйл ажиллагааг тусгасан журмыг боловсруулж мөрдөнө.

(б) Энэ зүйлийн (а)-д заасан журмаар шалгалтын нислэгийн тоног төхөөрөмжүүд нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 1/ Ашиглахаас өмнө, эсхүл тогтмол хуваарийн дагуу зохих стандартад нийцүүлэн тохируулга хийгдсэн байна. Тохируулга хийсэн үндэслэлийг баримтжуулж тайлан, бүртгэл үйлдэж хадгална;
- 2/ Шалгах төхөөрөмж бүр өөрийн тохируулгыг үзүүлэх индикатортай байх;
- 3/ Шалгалт тохиргоо, хэмжилтийн төхөөрөмжид дараах хяналтыг байнга тавина:

3.1. Тохируулгыг нь алдагдуулахгүй байхаар хамгаалагдсан байх;

3.2. Ашиглах, зөөх, хадгалж хамгаалах явцад нарийвчлал нь өөрчлөгдөхгүй байх;

(в) Хэрэв байгууламжийн хэмжилт тохиргооны шалгалтын нислэгийг холбогдох гэрээний дагуу бусад байгууллагын тоног төхөөрөмж ашиглан гүйцэтгэх бол тухайн төхөөрөмж нь энэ зүйлийн (б)-д заасан шаардлагыг хангасан байна.

(г) Шалгалтын нилэгийн байгууллага нь дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байх ба бүртгэл хөтөлж хяналтандаа байлгана. Үүнд:

- 1/ Шалгалтын нислэгийн тоног төхөөрөмжүүдэд шаардлагатай сэлбэг, хэрэгслийг хяналтандаа байлгах журам;
- 2/ Шалгалтын нислэгийн тоног төхөөрөмжүүдэд гарсан гэмтэл, тэдгээрийг засварласан арга хэмжээ;
- 3/ Ашиглалт үйлчилгээний зааврууд;
- 4/ Төлөвлөгөөт тохиргоо, үйлчилгээ хийгдсэн байдал.

## **В БҮЛЭГ. ШАЛГАЛТЫН НИСЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

### **Ес. Үйл ажиллагааны журам**

(а) Навигаци, ажиглалтын тоног төхөөрөмж, байгууламжуудын шалгалт, тохиргооны нислэгийг шалгалтын нислэгийн үйл ажиллагааны журмын дагуу гүйцэтгэнэ.

(б) Шалгалтын нислэгийн үйл ажиллагааны урьдчилсан төлөвлөлтийг тоног төхөөрөмж, байгууламжууд тус бүрээр нь ИНЕГ-ын даргаас хүлээн зөвшөөрсөн байна.

(в) Тоног төхөөрөмж, байгууламжуудын шалгалтын нислэгийн үйл ажиллагааны журам нь давтагдах бол ИНЕГ-ын даргаас зөвшөөрөл шаардахгүй байж болно.

### **Арав. Нислэгийн цаг**

(а) Шалгалтын нислэгийн цагийг тухайн байгууламж болон тоног төхөөрөмжийн тус бүрээс хамаарч тогтоох ба дараах хэсгээс бүрдэнэ.

- 1/ Шалгалтын нислэг хийх байгууламж хүрэх нислэгийн цаг (trip time);
- 2/ Тоног төхөөрөмжийн шалгалтын нислэгийн цаг;

(б) Шалгалтын нислэг үйлдэх агаарын хөлгийн хурд харилцан адилгүй байдаг тул тухайн байгууламж болон тоног төхөөрөмжийн тус бүрээс хамаарч зайн утгыг үндэслэнэ.

- 1/ Шалгалтын нислэг хийх байгууламж хүрэх зайг агаарын хөлгийн чиг шулуун нислэгийн хурдаар харьцуулж нислэгийн цагийг тооцно;
- 2/ Тоног төхөөрөмжийн шалгалтын нислэгийн цагийг агаарын хөлгийн чиг шулуун нислэгийн хурдын 60%-р тооцож нислэгийн цагийг тооцно;
- 3/ шалгалтын нислэгийг багцалсан (block) цагаар тооцно.

#### **Арван нэг. Шалгалтын нислэгийн төрөл**

(а) Дараах төрлийн шалгалтын нислэгүүд хийгдэнэ. Үүнд:

- 1/ *Хүлээн авах шалгалтын нислэг.* Агаарын навигацийн үйлчилгээний навигаци болон ажиглалтын тоног төхөөрөмж, байгууламжуудыг шинээр, эсхүл шилжүүлэн суурилуулсан тохиолдолд техникийн тодорхойлолтоор тавигдсан шаардлагууд хангагдаж байгаа эсэхийг баталгаажуулах үүднээс энэ төрлийн шалгалтын нислэг заавал хийгдсэн байна.
- 2/ *Хуваарьт шалгалтын нислэг.* ICAO-гийн стандарт, шаардлагууд хангагдаж байгааг баталгаажуулах үүднээс энэ шаардлагын 12-т заагдсан давтамжтайгаар навигаци болон ажиглалтын тоног төхөөрөмж, байгууламжуудад энэ төрлийн шалгалт, тохиргооны нислэг заавал хийгдсэн байна.
- 3/ *Тусгай (захиалгат) шалгалтын нислэг.* Навигаци болон ажиглалтын тоног төхөөрөмж, байгууламжуудын сигналын гаралтанд ямар нэгэн өөрчлөлт орохоор засвар, өөрчлөлт хийгдсэн, эсхүл нисгэгчийн мэдээллийн дагуу болон осол, зөрчлийн дараа баталгаажуулалт хийх үүднээс ашиглагч байгууллагаас хүсэлт гаргасан эсхүл, эрх бүхий байгууллагаас шаардсан то
- 4/ Тохиолдолд энэ төрлийн шалгалтын нислэг хийгдэнэ.

#### **Арван хоёр. Шалгалтын нислэгийн хуваарь, давтамж**

(а) Шалгалтын нислэгийн хуваарийг тогтоохдоо дараах мэдээллүүдийг үндэслэнэ. Үүнд:

- 1/ ICAO-гоос гаргасан холбогдох мэдээлэл;
- 2/ Тухайн байгууламжийн найдвартай ажиллагааны холбогдох өгөгдлүүд;
- 3/ Тухайн байгууламжийн эсхүл ижил төрлийн байгууламжийн найдвартай ажиллагааны шалгагдсан мэдээлэл, тухайн байгууламжийн ажиллах орчны тогтвортой байдал.

(б) Шалгалтын нислэгийн хуваарийг ИНД-171-р гэрчилгээжсэн Агаарын навигацийн үйлчилгээний техникийн байгууллагын хүсэлтийг үндэслэн тогтоож, ИНЕГ-ын даргад мэдэгдэнэ.



(в) Навигаци, ажиглалтын тоног төхөөрөмж, байгууламжуудын шалгалт, тохиргооны нислэгийн хуваарийг гаргахдаа дараах давтамжийг үндэслэнэ. Үүнд:

<i>Тоног төхөөрөмж</i>	<i>Давтамж</i>
ILS	12 сар хүртэл;
SSR	тусгай (захиалгат);
DVOR enroute	36 сар;
DVOR approach	12 сар хүртэл;
DME	хамт суурьлагдсан төхөөрөмжтэй хавсарч;
NDB	тусгай (захиалгат);
AFL	PAPI гэрэлтэй хавсарч;
PAPI	CAT I –ын хувьд 12 сар, бусад нь 24 сар;
COM	тусгай (захиалгат);
ADS-B, MLAT	тусгай (захиалгат).

(г) Шинээр суурилуулагдсан байгууламж, тоног төхөөрөмжийн удаах шалгалтын нислэгийн хуваарийг (в)-д зааснаас бага хугацаагаар тогтоож болно.

(д) Навигаци, ажиглалтын тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа (reliability), хэрэгцээ болон бэлэн байдлын (availability) үзүүлэлтээс хамаарч тоног төхөөрөмжийн ашиглалт хариуцсан байгууллагын хүсэлт, нислэгийн аюулгүй ажиллагааны байцаагчийн дүгнэлтэнд үндэслэн, шалгалтын нислэгийн давтамжийг ИНЕГ-ын дарга өөрчилж болно.

(е) Нислэгийн журмыг нислэгээр баталгаажуулахад дараах зарчмыг мөрдөнө. Үүнд:

- 1/ Шинээр зохиогдсон буюу өөрчлөлт орсон хэрэглэлийн нислэгийн журам нь ИНД-173.57 (б) болон ICAO Doc 9906 Vol V “Validation of Instrument Flight Procedure”-ийн 1.2.5-ын заалтуудад хамрагдах тохиолдолд нислэгээр баталгаажуулахгүй;
- 2/ Нислэгээр баталгаажуулах шийдвэрийг ИНЕГ-ын дарга гаргана.

#### **Арван гурав. Шалгалтын нислэгийн өмнөх үйл ажиллагаа**

(а) Шалгалтын нислэгийн өмнө дараах ажиллагаанууд заавал хийгдсэн байна. Үүнд:

- 1/ Шалгалтын нислэг хийгдэх тоног төхөөрөмжийн газрын хэмжилт хийгдэж, шаардлага хангах хэмжээнд тохиргоо хийгдсэн байх;
- 2/ Ашиглалт үйлчилгээ хариуцсан байгууллагаас шалгалтын нислэгийн үеийн тоног төхөөрөмжийн газрын хэмжилт, тохиргоо хийж гүйцэтгэх инженер техникийн ажилтнууд томилогдсон байх;
- 3/ Шалгалтын нислэгийн баг, нисэх бүрэлдэхүүн, нислэгийн удирдагч болон энэ шаардлагын 6.1.2-т заагдсан инженер техникийн ажилтнууд хамтран шалгалтын нислэгийн үйл ажиллагааг зохион байгуулах талаар нислэгийн өмнөх яриаг хийж баримтжуулсан байх;
- 4/ Тусгай шалгалтын нислэг гүйцэтгэх бол түүнд шаардлагатай мэдээллүүдийг цуглуулсан байх;
- 5/ Ашиглалт үйлчилгээ хариуцсан байгууллагаас шаардлагатай NOTAM мэдээг зарлуулсан байх;
- 6/ Шалгалтын нислэгийг гүйцэтгэх талаар холбогдох байгууллагуудтай зөвшилцсөн байх;

### **Арван дөрөв. Шалгалтын нислэгийн үйл ажиллагаа**

(а) Аливаа шалгалт тохиргооны нислэг нь энэхүү батлагдсан шалгалтын нислэгийн шаардлагын дагуу хийгдэнэ.

(б) Зориулалт, тус бүрээр нь шалгалтын нислэгийн журмыг ICAO-ийн Doc 8071 /Manual on Testing of Radio Navigation Aids/ баримт бичгийн дагуу боловсруулж, ИНЕГ-ын даргаар батлуулсан байна.

(в) Шалгалтын нислэгийн төрлөөс шалтгаалан хийгдэх хэмжилт тохиргоонууд нь өөр өөр байж болох ба шалгалтын нислэгийн журмуудад тэдгээрийг тодорхойлсон байна.

(г) Шалгалтын нислэгийн гүйцэтгэхээс өмнө тухайн байгууламжийн газар дээрх хэмжилтийг ашиглагч байгууллагаас авсан байна.

(д) Шалгалтын нислэгийн үед Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага болон шалгалтын нислэгт оролцож буй газрын багуудтай үл ойлголцол үүсгэхгүй байх радио холбооны журамтай байна.

(е) Шалгалтын нислэг үйлдэх баг нь дараах сэдвүүдээр сургалтад хамрагдсан байна. Үүнд:

- 1/ Хэмжилт бүрт хийгдэх шалгалтын нислэгийн төрлүүд;
- 2/ Шалгалт тохиргоо хийгдэх байгууламж, тоног төхөөрөмжийн шалгалтын нислэгийн өмнөх газрын хэмжилт тохиргоо;
- 3/ Агаарын хөлгийн байрлал тодорхойлоход шаардлагатай төхөөрөмжүүд;
- 4/ Хэмжилтийн тоног төхөөрөмжийн ашиглалтын заавар;
- 5/ Шалгалтын нислэгийн тайлан бэлтгэх заавар;
- 6/ Бичлэг ба график боловсруулах заавар;
- 7/ Шалгалт, тохиргооны нислэгийн үр дүнг үндэслэн тоног төхөөрөмжид ашиглалтанд тэнцэх гэрчилгээ олгох журам;
- 8/ Шууд хэмжилтийн тоног төхөөрөмжөөс гарч буй үр дүнгээс өөрөөр тооцоолох аргачлалууд.

(ё) Шалгалтын нислэгийн байгууллага хэмжилт, шалгалт, тохиргоо хийж гүйцэтгэх шалгалтын нислэгийнхээ хуваарийг жилээр гаргасан байна.

(ж) Агаарын навигацийн үйлчилгээний байгууламжийн хэмжилт тохиргоог хийж гүйцэтгэх шалгалтын нислэгийн хуваарийг холбогдох тайлбарын хамт гаргасан байх ба шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллагаас нэмэлт тайлбар, нотолгоог шаардаж болно.

### **Арван тав. Шалгалтын нислэгийн дараах үйл ажиллагаа**

(а) Шалгалтын нислэгийн дараа дараах ажиллагаанууд хийгдсэн байна. Үүнд:

- 1/ Шалгалтын нислэгийн баг нь шалгалт тохиргооны нислэгийн тайлангуудыг боловсруулан гаргаж ИНЕГ-ын даргад хүргэнэ.
- 2/ Шалгалтын нислэгийн тайланд заагдсаны дагуу ашиглалт үйлчилгээ хариуцсан байгууллага нь шаардлагатай арга хэмжээнүүдийг авна.
- 3/ Хэрвээ байгууламж, тоног төхөөрөмжийн үзүүлэлтэнд ноцтой өөрчлөлт гарсан бол ашиглалт үйлчилгээ хариуцсан байгууллагаас NOTAM мэдээ зарлуулах ажиллагааг зохион байгуулна.

## **Г БҮЛЭГ. ШАЛГАЛТЫН НИСЛЭГИЙН ТАЙЛАН, БИЧЛЭГ БА ГРАФИКУУД**

### **Арван зургаа. Шалгалтын нислэгийн тайлан**

(а) Шалгалтын нислэгийн тайланг Байгууллагын үйл ажиллагааны зааврын хавсралтаар батлагдсан маягтын дагуу гаргана. Энэхүү тайланд дараах мэдээллүүдийг тусгасан байна. Үүнд:

- 1/ Байгууламж, тоног төхөөрөмжийн нэр, дуудлага;
- 2/ Үйл ажиллагааны төрөл;
- 3/ Огноо;
- 4/ Тайлангийн дугаар /тайлангийн дугаар нь дахин давтагдахааргүй байна/;
- 5/ Шалгалтын нислэгийн төрөл;
- 6/ Агаарын хөлгийн бүртгэлийн дугаар;
- 7/ Шалгалтын нислэг хийгдсэн байгууламж, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгчээс олгосон төрөл;
- 8/ Шалгалтын нислэгт оролцсон бүх ажилтнуудын нэрс, албан тушаал;
- 9/ Хийгдсэн бүх хэмжилтийн утгууд;
- 10/ Хавсралт материалуудын товч мэдээллүүд;
- 11/ Байгууламж, тоног төхөөрөмжийн тохиргоог хийж гүйцэтгэхийн тулд хийсэн нэмэлт нислэгүүдийн мэдээллүүд;
- 12/ Байгууламж, тоног төхөөрөмжийн ажиллагааны талаарх агаарын хөлгийн даргын үнэлгээ;
- 13/ Байгууламж, тоног төхөөрөмжийн ажиллагааны талаарх шалгалтын нислэгийн шалгагч инженерийн үнэлгээ, дүгнэлт;
- 14/ Яаралтай арга хэмжээ авах шаардлагатай дутагдлын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
- 15/ Шаардлагад нийцэх, эсхүл үл нийцэх талаарх үнэлгээ;
- 16/ Шалгагч инженерүүдийн гарын үсэг;
- 17/ Нисгэгчийн гарын үсэг;
- 18/ Шалгалтын нислэгийн тайланг баталгаажуулсан эрх бүхий албан тушаалтны гарын үсэг.

### **Арван долоо. Бичлэг ба графикууд**

(б) Шалгалтын нислэгийн тайланд шалгалтын нислэгийн үр дүнг харуулсан бичлэг болон графикийг хавсаргахдаа хэмжилтийн утгууд зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэх нь харагдахаар хуваарьтай хийгдсэн байна.

(в) Бичлэгүүд болон графикийг байгуулахад ашиглагдсан түүхий өгөгдлүүд нь дахин боловсруулах боломжтой байхаар хадгалагдсан байна.

(г) Бичлэгийн хувьд хэмжилт хийгдсэн хугацаа болон агаарын хөлгийн байрлалтай уялдсан байхаар тэмдэглэгдсэн байна.

(д) Бичлэг болон график бүрт дараах мэдээллийг зайлшгүй оруулсан байна. Үүнд:

- 1/ Индексжүүлсэн дугаар;
- 2/ Огноо;
- 3/ Шалгалтын нислэгийн төрлийн тодорхойлолт;
- 4/ Нисэх буудлын нэр;
- 5/ Шалгалтын нислэг хийсэн байгууламж, тоног төхөөрөмжийн дуудлага.

(е) Шалгалтын нислэгийн бэлтгэл ажил, шалгалтын нислэгийн үе, шалгалтын нислэгийн дараах хийгдсэн ажиллагаануудыг баримтжуулж, 2 жилээс доошгүй хугацаагаар хадгална.

(ё) Шалгалтын нислэгийн тайлан, тэдгээрт ашиглагдсан өгөгдлүүд, бичлэг, графикуудыг тухайн тоног төхөөрөмжийг нислэгийн үйл ажиллагаанд ашиглахыг зогсоох хүртэлх хугацаагаар хадгална.

#### **Д БҮЛЭГ. ШАЛГАЛТЫН НИСЛЭГИЙН БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ЧАНАР БАТАЛГААЖУУЛАЛТ БА ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА**

##### **Арван найм. Дотоод чанар баталгаажуулалт**

(а) Байгууллага нь энэ баримт бичигт тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх шат бүрт чанарын удирдлага гүйцэтгэхэд шаардлагатай журам, үйл явц, нөөцийг багтаасан, зөв зохион байгуулалттай чанарын тогтолцоог нэвтрүүлсэн байна.

(б) Байгууллагын чанарын тогтолцооны хэрэгжилтийг аудитаар тогтоох ба залруулах шаардлагатай үл тохирол илэрвэл түүний шалтгааныг тогтоож, зохих арга хэмжээг авна.

(в) Аудитын бүх дүгнэлт болон үл тохирлыг залруулах арга хэмжээнүүд нь баримттай, зохих бүртгэлтэй байна.

(г) Чанарын удирдлагын тогтолцооны баримт бичгүүдэд дараах үйл ажиллагаа, мэдээллийг тусгасан байна. Үүнд:

- 1/ Байгууллагын үйл ажиллагааны чанарын бодлого, зорилтууд;
- 2/ Илрүүлсэн үл тохиролд дүн шинжилгээ хийх болон илэрсэн үл тохиролын шалтгааныг тогтоох, залруулах ажиллагааны журам
- 3/ Байгууллага болон ажилтнуудын аюулгүй ажиллагаанд хамааралтай хариуцлагууд;
- 4/ Дотоод аудит шалгалтын үйл ажиллагаа;
- 5/ Аюулгүй ажиллагаанд хамааралтай мэдээлэх үйл ажиллагаа;
- 6/ Шалгалтын нислэгүүд зааврын дагуу хийгдэж байгаад тавигдах хяналтын үйл ажиллагаа;
- 7/ Үйлчилгээнд байгаа болон болзошгүй аюул эрсдлийг тодорхойлох, үнэлэх, хянах ба урьдчилан сэргийлэх ажиллагааны журам;
- 8/ Энэ баримт бичгийн дагуу чанарын удирдлагын тогтолцооны нийцтэй, үр дүнтэй байдлыг бататгах удирдлагын дүн шинжилгээний журам
- 9/ Дотоод нэгжийн болон хамтран ажилладаг бусад алба салбаруудтай чанарын удирдлагын талаар харилцах үйл ажиллагаа зэргийг багтаасан байна.

(д) Байгууллага нь аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хяналтандаа байлгах бөгөөд түүний үр дүнг дээшлүүлж, шаардлагатай тохиолдолд аюулгүй ажиллагааг хангаж, бататгах зорилгоор холбогдох өөрчлөлтийг хийнэ.

(е) Чанар, хангалт хариуцсан ажилтан нь шалгалтын үйл ажиллагааны талаар байгууллагын удирдах албан тушаалтантай шууд харьцана.

##### **Арван ес. Үйл ажиллагааны зааварт тавигдах шаардлага**

(а) Шалгалтын нислэгийн үйл ажиллагааны зааврыг эрх бүхий байгууллагаар хянуулж, баталгаажуулагдсан байна.

(б) Байгууллагын Үйл ажиллагааны зааварт дараах мэдээллүүдийг тусгасан байна. Үүнд:

- 1/ Байгууллагын нэрийн өмнөөс үүрэг хүлээсэн удирдах албан тушаалтан нь дараах үүргийг хүлээхээ баталгаажуулж, аюулгүй ажиллагааны Батламж гаргасан байна. Үүнд:
  - 1.1. Үйл ажиллагааны заавар нь энэхүү баримт бичигт заасан шаардлагыг хангасан; ба

1.2. Байгууллага нь цаашид энэхүү үйл ажиллагааны зааврын дагуу ажиллах болно;

- 2/ Энэхүү баримт бичгийн гуравт заасан ажилтнуудын мэдээлэл болон тэдгээрийн үүрэг хариуцлага, ажлын байрны тодорхойлолтууд;
- 3/ Энэхүү баримт бичгийн гуравт заасан ажилтнуудын харилцан ажиллагааг харуулсан байгууллагын бүтэц;
- 4/ Дараах шаардлагыг хангаж байгааг нотлон харуулсан журам, заавар, нотолгоо, эсхүл байгууллагын үйл ажиллагааны удирдлагын баримт бичигт заагдсан ишлэл байж болно. Үүнд:
  - 4.1. энэ баримт бичгийн Б Бүлэг, Шалгалтын нислэгийн байгууллагад тавигдах шаардлагыг хангасан байдал;
  - 4.2. энэ баримт бичгийн В Бүлэг, Шалгалтын нислэгийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагууд;
  - 4.3. энэ баримт бичгийн Г Бүлэг, Шалгалтын нислэгийн тайлан, бичлэг ба графикуудад тавигдах шаардлагыг хангасан байдал;
  - 4.4. энэ баримт бичгийн арван зургаад заасан дотоод хяналт, чанар баталгаажуулалтын тогтолцоог нэвтрүүлсэн байдал.
- 5/ Үйл ажиллагааны зааврыг хянах, нэмэлт өөрчлөлт оруулах болон түгээх журам;
- 6/ Байгууллагын эрхэлж буй бусад үйл ажиллагааны тодорхойлолтууд.

### **Хорь. Үйл ажиллагааны зааварт нэмэлт өөрчлөлт оруулах**

(а) Байгууллага нь Шалгалтын нислэгийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалтад орсон өөрчлөлтийг Үйл ажиллагааны зааварт тусган хэрэгжүүлнэ.

(б) Үйл ажиллагааны зааварт оруулсан нэмэлт өөрчлөлт нь холбогдох дүрмийн шаардлага болон Үйл ажиллагааны зааварт нэмэлт, өөрчлөлт оруулах журамд нийцсэн байна.

(в) Үйл ажиллагааны зааварт оруулах нэмэлт, өөрчлөлтийг ИНЕГ-ын даргад хүргүүлж, зохих зөвшөөрөл авсан байна.

(г) Байгууллага нь дараах нэмэлт өөрчлөлтүүдийг оруулах тохиолдолд эрх бүхий газарт урьдчилан мэдэгдэнэ. Үүнд:

- 1/ Удирдах албан тушаалтан өөрчлөгдөх;
- 2/ Удирдах ажилтнууд өөрчлөгдөх.

(д) Үйл ажиллагааны зааварт энэ зүйлийн (г)-д заасан өөрчлөлт орсон тохиолдолд ИНЕГ-ын эрх бүхий байгууллагаас үйл ажиллагаа явуулах тусгайлсан нөхцлийг тодорхойлж өгч болно.

## **Е БҮЛЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ШААРДЛАГА,**

### **Хорин нэг. Үндсэн шаардлага**

- (а) Байгууллага нь дараах үндсэн шаардлагыг биелүүлнэ. Үүнд:
- 1/ Үйл ажиллагааны зааврын хүчин төгөлдөр хувийг ажлын байр бүрт байршуулах;
  - 2/ Үйл ажиллагааны зааварт тусгагдсан журам, шалгуурыг мөрдөж ажиллах;
  - 3/ Энэхүү баримт бичгийн шаардлагуудыг байнга мөрдөж ажиллах.

### **Хорин хоёр. Хариуцлага**

Энэхүү шаардлагыг хангаагүй аливаа шалгалтын нислэг гүйцэтгэх, шаардлага хангаагүй шалгалтын нислэг хийгдсэн байгууламж, тоног төхөөрөмж, нислэгийн журмыг агаарын навигацийн үйлчилгээнд ашиглахыг хориглоно.